



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 19


Бөхт

ГБaгийн Иргэдийн Нийтийн Хурлын даргын ажлыг
үнэлж, дүгнэх, урамшуулал олгох журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын ИргэдийнТөлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Багийн ИНХ-ын даргын ажлыг үнэлж дүгнэх, урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг БИНХ-ын дарга, Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид болон нарийн бичгийн дарга Д.Уранбилэг нарт даалгасугай.

ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 -р сарын 12-ны өдрийн 19 -р тогтоолын хавсралт

ӨНДӨРШИЛ СУМЫН БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ДАРГЫН АЖЛЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ

Зорилго: Багийн ИНХурал, түүний Тэргүүлэгчдээс нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж буй ажлыг эрчимжүүлэх, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс Багийн ИНХ-ын ажлыг удирдан чиглүүлж, хяналт тавих, ажлыг нь үнэлж дүгнэх, урамшуулал олгоход оршино.

Нэг. Шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл	Тоон шалгуур	Оноо
1	БИНХ болон Тэргүүлэгчдийн хуралдааныг тогтмолжуулах	Хурлаар хэлэлцэх асуудал, дараалал, дотоод журам, хуралдааны бэлтгэл хангах төлөвлөгөө, гарах шийдвэрийн төслийг урьдчилан бэлтгэсэн байх Хуралдааны материалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу үйлдэж, архивлаж хүлээлгэн өгсөн байх	БИНХ 2 удаа, Тэргүүлэгчдийн хурал 4 удаа	5 оноо
2	БИНХ-ын Тэргүүлэгчдийн жилийн ажлын төлөвлөгөөтэй ажиллах	Төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн баталсан байх Төлөвлөгөөний хэрэгжилтийг БИНХ-ын хуралдаанд тайлагнасан байх Ажлын тайланг улирал бүр ИТХ-ын ажлын албанд ирүүлсэн байх	2 удаа /хагас, бүтэн жилээр/	5 оноо
3	Багийн Засаг даргын ҮАХ-ийг батлах, тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх	ҮАХ-ийг хурлаараа хэлэлцсэн байх Хэрэгжилтийг хурлаараа хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгсөн байх	2 удаа /хагас, бүтэн жилээр/	5 оноо
4	Хууль, тогтоомж, дээд шатны болон сум, багийн хурал, Тэргүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийг сурталчилах	Хууль, тогтоомжоор багийн иргэддээ сургалт зохион байгуулах Гарсан шийдвэрийг сурталчилах, Шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Сургалт 2 удаа Шийдвэр сурталчилах 2 удаа Тайлагналт жилийн эцэст 1 удаа	5 оноо
	Багийн иргэдийнхээ үндсэн ба журам үүргийн биелэлтийг	ГХУС, сахилга дэг журмыг бэхжүүлэх талаар зохиосон ажил	2 үр дүнтэй ажил зохиосон байх	5 оноо

	хангуулах	Татвар, төлбөр, хураамжийг хугацаанд нь төлсөн байх	4 удаа мэдээлэгдсэн байх	
6	Төрийн дээд шагнал, одон медальд тодорхойлох	БИНХ-аараа хэлэлцэж шийдвэрлэсэн байх Холбогдох хууль, журмын дагуу материалыг бүрдүүлж шийдвэрийн хамт ИТХ-ын ажлын албанд ирүүлэх	2 удаа /эхнийх нь оны эхэнд/	5 оноо
7	БИНХ-ын үйл ажиллагааны дэвтэр хөтлөлт	Дэвтрийг тогтмол хөтлөх Багийн Засаг даргаар хүн ам, нийгэм, эдийн засгийн суурь судалгааг гаргуулан авсан байх Статистик мэдээ мэдээллийг үнэн зөв бөглөх	Дэвтэр хөтлөлт, судалгааны чанарыг харгалзан үнэлгээг өгнө	5 оноо
8	Иргэдийн санал, өргөдөл, гомдол шийдвэрлэлт	СӨГ бүртгэх дэвтэрт бүртгэсэн байх Шийдвэрлэлтийн талаар амаар буюу бичгээр заавал хариу өгсөн байх Тайланг иргэдэд танилцуулсан байх	2 удаа тайлагнагдсан байх	5 оноо
9	ГХУС ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах	Багийн ГХУС жилийн төлөвлөгөөтэй байх, хэрэгжилтийг тайлагнах ГХУС чиглэлээр Багийн Засаг даргын хийсэн ажлын тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгсөн байх	2 удаа /хагас, бүтэн жилээр/	5 оноо
10				

Хоёр. Ажил дүгнэх, урамшуулал олгох

2.1. Ажлыг улирал бүрийн сүүлийн сарын 15-нд ИТХ-ын дарга дээрх үзүүлэлтийн дагуу 1-5 оноогоор дүгнэж, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж шийдвэрлэнэ.

2.2. Авсан онооны нийлбэрээр урамшууллыг олгоно.

А. 60-аас дээш оноо авбал Санаачлагатай сайн гэж үнэлэн урамшууллыг 100 хувь,

Б. 59-өөс доош оноо авбал Хангалтгүй гэж үнэлэн урамшууллыг олгохгүй.

2.3. Хангалтгүй оноо авсан БИНХ-ын даргад эхний удаа сануулах, 2 дахь удаа бол урамшууллын 20 хувийг хасах, 3 дахь удаа бол БИНХ-аас чөлөөлөх саналыг Багийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд уламжлах болно.

СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД